158

ОРХОН АЙМАГ

# ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр　　　　Дугаар 02/29　　　　Жаргалант сум

Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Эрүүл Жаргалантчууд хөтөлбөрийн 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Жаргалсайхан), Засаг дарга (Л.Учрал) нарт даалгасугай.

ДАРГА　　　　Ш.БИЛГҮҮНБААТАР

6125010066

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны
02/19 тогтоолын хавсралт

**“ЭРҮҮЛ ЖАРГАЛАНТЧУУД” ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025.12.12

Жаргалант сум

| № | Хөтөлбөрийн зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | | Санхүүжилт | | Хариуцан хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Суурь он | Суурь түвшин | Зорилтот түвшин (2026 он) | Санхүүжилт сая.төг | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | |
| 1 | **Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:**<br>Орон нутгийн төрийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын идэвх санаачилга, дэмжлэг | 1.1 Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан насанд тохирсон өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах | - Хамрагдсан иргэдийн тоо<br>-Илрүүлсэн өвчлөл<br>- Эмчлэгдсэн байдал | Тоон үзүүлэлт<br>Хувь | 2025 | Насанд тохирсон эрт илрүүлэг үзлэгийн хувь 38,2 хувь байна. | Насанд тохирсон өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувийг улс, аймгийн түвшнээс буурруулахгүй, зохих үр дүнд хүрсэн байна. | - | ЭМДС<br>ОНТ | ЭМТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | туслалцаа, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн оролцоотойгоор нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах | 1.2 Хөгжлийн бэрхшээлтэй, эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо эмчилгээнд хамруулах | - Хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь<br>-Илрүүлсэн өвчлөл<br>- Эмчлэгдсэн байдал | Тайлан<br>Тоон үзүүлэлт<br>Хувь | 2025 | Бүртгэлтэй эмэгтэйчүүдийн 95 орчим хувь хамрагддаг. | Бүртгэлтэй эмэгтэйчүүдийг 98 хувиас доошгүй хамруулж, оношилгоо эмчилгээнд хамрагдсан байна. | - | ОНТ<br>ЭМТ-ийн төсөв | ЭМТ |
| | | 1.3 Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | - Хамрагдсан хүүхдийн тоо<br>-Илрүүлсэн өвчлөл<br>- Эмчлэгдсэн байдал | Хувь | 2024 | Сургууль болон цэцэрлэгийн хүүхдийг 100 хувь урьдчилан сэргийлэх үзлэгт оруулсан, хамгаалалтын болон фторт түрхлэг хийгдсэн, бүх хүүхэд шүдний карттай болсон. | Давтан үзлэг, хамгаалалтын түрхлэг хийх, шаардлагатай хүүхдүүдийн байнгын шүдний эмчилгээг хийсэн байна. | - | ЭМДС-ийн санхүүжилт | ЭМТ |
| | | 1.4 Сумын хүн амд | -Сургалт, нөлөөллийн | Тайлан<br>Тоон | 2025 | Сүүлийн жилүүдэд | Улиралд 1-2 удаа олныг хамарсан | - | ОНТ | ЭМТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрүүл мэндийн боловсрол олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх, иргэдийн эрүүл мэндийн талаарх хүчин чармайлтыг дэмжих, урамшуулах, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах | ажлын тоо<br>-Тайлан | үзүүлэлт | | санхүүгийн хүрэлцээгүй байдлаас болж ЭММСС-ны ажлууд төдийлөн олныг хамруулж зохион байгуулагдаагүй | сургалт, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн байна. | | | |
| | | 1.5 Урьдчилан сэргийлэх | -Урьдчилан сэргийлэх үзлэгийн | Тайлан<br>Хамралт | 2025 | Сумын нийт иргэд төрөлжсөн нарийн | Иргэдэд ЭМД төлөлтөөс үл шалтгаалж үзлэгт | 25.0 сая | ОНХС | ЭМТ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзлэгийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, 2 болон 3 дахь шатлалын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах | тоо<br><br>- Хамрагдсан иргэдийн тоо<br><br>-Илрүүлсэн өвчлөл | ын хувь | | мэргэжлийн эмч нарын үзлэгт орох боломжгүй байгаа. Өнгөрсөн онд хийгдсэн үзлэг үр дүнтэй болсон. | хамрагдах боломжийг гаргаж, өвчнийг эрт хугацаанд нь илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг ойроос хүртэх боломж бүрдэнэ. | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1.6 Айл өрхөөр улирал тутамд эмч, мэргэжилтний хамтарсан багаар явж, үзлэг оношилгоо хийж, өвчлөлийг илрүүлж, ЭМД төлөөгүй, эмнэлэгт хандаагүй иргэдийг үзлэгт хамруулах, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулах | -Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, тайлан | Хувь | 2025 | Зөвхөн аймаг сумаас зохион байгуулсан төлөвлөгөөт арга хэмжээгээр ДУБ-аар эмч, мэргэжилтнүүд үзлэг хийдэг. | Сумын нийт айл өрх болон хүн амын судалгаа шинэчлэгдэж, урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн байна. | 2.0 сая | ОНХС | ЭМТ |
| 2 | **Зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний** | 2.1 Эмнэлгийн яаралтай тусламжийн | - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтн | Хувь | 2025 | Яаралтай тусламжийн хэсгийн зохион байгуулалт | Яаралтай тусламжийн хэсгийн зохион байгуулалт сайжирч, ажиллаж | - | ЭМТ-ийн төсөв | ЭМТ |

164

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **чиглэлээр:** Эмнэлгийн тусламж үйлчилгээг сумын хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, ил тод, хариуцлагатай, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн анхан шатны тусламжийг хөгжүүлнэ. | хэсгийг шинэчлэн зохион байгуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдыг багаар ажиллах, чадавхжуулах сургалтад хамруулах | ий тоо<br>-Нэмэгдсэн аппарат, тоног төхөөрөмжийн нэр, тоо төрөл, ашиглалт | | | оновчгүй, ажиллаж байгаа их эмч, сувилагч нар сургалтад хамрагдаагүй. | байгаа их эмч, сувилагч нарын мэдлэг нэмэгдэж, дадлагажин иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ. | | | |
| | | 2.2 Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | -Эмч, мэргэжилтний хангалт<br>-Тусламж, үйлчилгээний төрөл, тоо, тайлан | Хувь | 2025 | Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээний нэр төрөл цөөн. | Уламжлалт, сэргээн засах, эмийн бус эмчилгээний тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. | - | ЭМТ-ийн төсөв | ЭМТ |
| 3 | **Зорилт 3. Хүний нөөцийн** | 3.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтни | -Сургалтын тоо | | | Сургалтын агуулга, чиглэлийн хувьд | Хамрагдалтыг нэмэгдүүлж, багц цаг бүрэн биелж, | | ЭМТ- | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **чиглэлээр:** Эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлаг харилцааг сайжруулах, нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана. | йг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн болон, ажлын байрны, богино хугацааны болон зайн сургалтад хамруулах, мэргэжлийн чиглэлээр туршлага судлах, сэлгэн ажиллуулахад дэмжлэг үзүүлэх | - Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо<br>-Багц цагийн биелэлт | Тайлан<br>Биелэлтийн хувь | 2025 | хязгаарлагдмал хамрагддаг. | эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар нэмэгдсэн байна. | - | ийн төсөв | ЭМТ |
| | | Нийт ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, төрийн албан хаагчийг дэмжих хөтөлбөрт хамруулах | - Хамрагдсан ажилчдын тоо<br>-Тэтгэмжийн хэмжээ | Тайлан | 2025 | Эмч хөтөлбөрт хамрагдсан ажилчдын тоо харьцангуй цөөн байгаа | Нийгмийн дэмжлэгт хамрагдсан ажиллагсдын хувь нэмэгдсэн байна. | - | Хөтөлбөрийн зардал | ЭМТ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Зорилт 4. Эрүүл мэндийн технологийг сайжруулах**<br><br>Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа барилга байгууламж, оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүчин чадал, ашиглалт, хангалтын байдалд үнэлгээ, төлөвлөлт хийж, анхан шатны тусламжийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. | 4.1 Цахилгааны нөөц эх үүсвэрээр хангах | Хангагдсан байна. | Тайлан | 2025 | Цахилгаан тасарсан үед ажиллуулах цахилгааны эх үүсвэр байхгүй. | Цахилгаан тасарсан үед эмнэлгийн яаралтай тусламж болон дархлаажуулалтын хөргөгчний хэвийн ажиллах нөхцөл бүрдэнэ. | 5.0 сая | ОНХС | ЗДТГ |
| **Нийт төсөв: 32 сая төгрөг** | | | | | | | | | | |